БАТЛАВ.
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Л.ЦЭДЭВСҮРЭН

## 2023 ОНЫ УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР ХУДАЛДАН АВАХ "ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТ ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГТ ТАВИЛГА, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ"-ИЙН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

| № | Тоног төхөөрөмж | Дараах техникийн үзүүлэлт хангасан /эсхүл түүнтэй дүйцэх/ | Тоо, ширхэг | Нэгж үнэ /мян.төг/ | Нийт үнэ /мян.төг/ |
|---|---|---|---|---|---|
| **Багц-2: Тусгай хэрэгцээт сургуулийн тоног төхөөрөмж** | | | | | |
| 1 | Алхах дасгал хийхэд зориулсан шат YB-XFT-2 | Хүүхдийн доод мөчний булчингийн үйл ажиллагааг сайжруулна. Алхуулж сургахад зориулагдсан шат хэлбэрийн алхуулагч. Шат нь гишгүүр зөөлөвчтэй байна. Хэмжээ 2.5х*1.8*1.5 метр, 3 тал руугаа буудаг шаттай. Бариулаас барихад барьцтай, хүүхдэд тохирсон байх. | 30 | 1,750.0 | 52,500.0 |
| 2 | Зогсоогч | Хүүхдийн доод мөчний булчингийн үйл ажиллагааг сайжруулах, зогсоход дэмжлэг үзүүлнэ. Алхуулж сургахад зориулагдсан. Хэмжээ: 337*82*134-160cm | 30 | 1,500 | 45,000.0 |
| 3 | Тэнцвэрийн хавтан | Хүүхдийг тэнцвэрээ олж, зогсож сурахад дэмжлэг болно. 1.MNS ISO 0884 :1989 Модон тоглоомын стандартын 1.4 Модны эд ангийн нүдэнд ил харагдах гадаргуунд ан цав, хонхорхой, сэтэрхий зэрэг гэмтэлтэй байж болохгүй. Гадна гадаргууг сайтар зүлгүүрдэж, өнцөг, ирмэгүүдийг дарж өгсөн байна. Хөндлөвч мод нь яртай байж болохгүй. | 60 | 175.0 | 10,500.0 |
| 4 | Үсэрдэг тавцан /Jump/ | Булчингийн чангарлыг сулруулах, тэнцвэрээ олоход дэмжлэг болно. Дотор тоглох зориулалттай хүүхдийн үсэрдэг тавцан. Сайн чанарын удаан эдэлгээтэй материалаар хийгдсэн, мөн бариул хэсэг нь сайн чанарын төмрөөр хийгдсэн, бариул хэсэг нь хүүхдийн өндөрт тохируулах боломжтой. Тоглох хүүхдийн тоо: 1 Жингийн хязгаар: 25кг. 91.4см*91.4см*85см хэмжээтэй, 5.9кг жинтэй. Бариулаас барин үсрэх дээд хэмжээ: 66см. Бариулын тойргийн урт: 86.36см | 30 | 380.0 | 11,400.0 |
| 5 | Матрас /2м*1.20м/ | Саажилттай болон тулгуур эрхтэний бэрхшээлтэй хүүхдийн алхах, мөлхөх, үсрэх үйлдэл хийхэд аюулгүй байдалд дэмжлэг үзүүлнэ. Матрасны дотор хэсэг нь порлон, 2 талаар нь эсгийгээр хучигдсан байна. Бүрээсний дотор хэсэг даавуун, гадна тал нь берзинт /сайн чанарын хиймэл савхи/ байна. Матраснуудын хөөсний нягтшил 25кг/м3 (+/- 2 кг/м3), Хөөсний сунах чадвар ≥ 115 кПа, шахагдах даралт 40% нь 4,0 (+/- 0.5) кПа байна. Нэг ижил өнгөтэй байна. Хэмжээ: L2000 x W1500 мм, Зузаан нь 100 мм-ээс багагүй байна. | 15 | 350.0 | 5,250.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 6 | Бөмбөг /диаметр 25-30см/ | Бөмбөгийг дээш шидэж, ойлгож, өнхрүүлж, барьж авах, дамжуулах, давуулан шидэх булчингийн хөгжилд дэмжлэг болох. Хурц үнэргүй, ойлт сайтай, олон өнгөтэй, тоглоход зориулагдсан. Диаметр 25-30см. Бөмбөгний гадаргуу янз бүр байвал сайн. | 60 | 20.0 | 1,200.0 |
| 7 | Хөдөлмөр (Завгүй самбар) | Бүх төрлийн цоож цуургыг онгойлгох, түгжиж бэхлэх аргад суралцаж алив зүйлд эмх цэгцтэй байхад суралцах, гарын нийлмэл булчин буюу жижиг булчингийн хөгжлийг дэмжих Цоож, түлхүүр бүх хэсгүүд нь самбартайгаа холбоотой байна. Жижиг хэсэг хэсгээр салахгүй, мохоо үзүүртэй, хүүхдийн аюулгүй байдлыг хангасан байна. | 120 | 125.0 | 15,000.0 |
| 8 | Хэлхдэг тоглоом | Биет дүрсийг барих, тэмтрэх, мэдрэх, танин мэдэхүйг хөгжүүлэхэд дэмжлэг болох. MNS 0884:1978 баримтлана. Модоор хийгдсэн 6 өнгийн 4 өөр хэлбэртэй 30 ш модон шүрнүүд Шүрнүүдийг хэлхэх 4-5 ширхэг нарийн модон үдээс байна. Хайрцагт хийсэн, хайрцаг нь таггүй. 20см х20смх3.5см хэмжээтэй байна. | 60 | 35.0 | 2,100.0 |
| 9 | Товчилж сургах тоглоом | Модон хавтан, хэмжээ: 30 х 40 см, цахилгаан татах, тэлээ зүүх зэрэг 6 үйлдэл бүхий бамбаруушийг хувцаслах зорилготой, тусгай хэрэгцээт хүүхдийн гарын мэдрэхүйг сайжруулах зорилготой. Биет дүрсийг барих, тэмтрэх, мэдрэх, танин мэдэхүйг хөгжүүлэхэд дэмжлэг болох. MNS 0884:1978 баримтлана | 60 | 45.0 | 2,700.0 |
| 10 | Тоногтой шоо | Оюун ухаан, танин мэдэхүй, гарын жижиг булчингийн хөгжилд дэмжлэг болно. Дөрвөлжин модон шоо хэлбэртэй, 2 талдаа цоож, түлхүүр гэх мэт тоногтой байна. MNS 0884:1978 баримтлана | 71 | 20.0 | 1,420.0 |
| 11 | Мэдрэхүйн хайрцаг (сетээр) | Танин мэдэхүй, анхаарал төвлөрөлтийг хөгжүүлнэ. Шоо дөрвөлжин ээлхүүнт дүрс нь: 2 тал нь битүү, 2 тал нь гар орох хэмжээтэй нүхтэй, 2 тал нь задгай байна. | 71 | 50.0 | 3,550.0 |
| 12 | Зөөлөн сандал | Тулгуур эрхтний бэрхшээлтэй хүүхдийг амраах зөөлөн сандал, Хүүхдийн биеийн хэлбэрт ордог, хэрэглэхэд хялбар, тааламжтай мэдрэмжийг өгөх зөөлөн, буцаж хэвэндээ амархан ордог материалаар хийгдсэн, эдэлгээ даах чанартай, өнгө үзэмжтэй | 12 | 450.0 | 5,400.0 |
| | | **ДҮН:** | **619** | | **156,020.0** |
| **Харааны бэрхшээлтэй хүүхдийг дэмжих тоног төхөөрөмж** | | | | | |
| 1 | Сурагчийн брайль самбар | Брайль самбар нь 27 мөр, 30 нүдтэй, А4 хэмжээтэй, нугастай, цаасаа дунд нь хийн бичнэ. Хуванцар материалтай, хар болон хар хөх өнгөтэй | 20 | 320.0 | 6,400.0 |
| 2 | Шивүүр | Халтирахгүй загвартай, зүүдэг уяа хийх боломжтой, аюулгүй. Эмээл загвартай учир гарт эвтэйхэн | | | |
| 3 | Брайль цаас | Брайль цаас нь нягтрал сайтай, биетэй, зузаан, Термоформ цаас, Брайл цэгүүдийг маш сайн товойлгон гаргадаг өндөр чанартай байна. -1 боодолдоо /500 ширхэгтэй/<br>-А4 21см х 29.7 см хэмжээтэй<br>-Бор шаргал өнгөтэй<br>-Цэгийн гаралт сайтай | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 4 | Цаасгүйгээр бичиж, унших төхөөрөмж | Энэ нь анхны олон мөрт брайль цахим уншигч бөгөөд уншигчдад илүү их мэдээлэл авах боломжийг олгодог, харьцангуй жижиг хэмжээтэй ажил, сургуульдаа авч явах боломжтой зөөврийн төхөөрөмж юм. Дараах онцлог шинжүүдтэй. Үүнд:<br>-BRF болон PEF файл уншдаг<br>-360 нүдтэй буюу брайл үсгийн дөчин тэмдэгтээс бүрдсэн есөн мөртэй<br>-6 цэгийн брайл (хөгжим, математик, болон бүх хэлээр) болон товгор зурган дүрслэлийг уншина<br>-Хэмжээ: 14.5 " x 7.5 " x 1.5 " (37 см x 19 см x 4 см), 6 фт, (2.8 кг)<br>-3 чиглүүлэх товчлууртай<br>-9 мөр сонгох товчлуурууд<br>-Хам сэдвийн туслах товчлууртай<br>-40 нүд, 9 мөр буюу 360 брайл нүдтэй<br>-25-27 стандарт мөртэй<br>-Монгол хэл нэмэгдэх шаардлагатай<br>-Унших гадаргуу нь цаас шиг мэдрэгдэх, хуванцар материалтай | 4 | 16,000.0 | 64,000.0 |
| 5 | Дэлгэц уншигч програм хангамж | Дэлгэц уншигч /Яриа хөрвүүлэгч/. Монгол дэлгэц уншигч программ<br>- Монгол хэлээр орчуулагдсан NVDA нь Windows үйлдлийн систем дээр ажилладаг програм юм. Энэхүү дэлгэц уншигч програм нь брайль бичгийн төхөөрөмжүүд болон ярьдаг хоолойны тусламжтайгаар хярааны бэрхшээлтэй иргэдэд энгийн хүн шиг компьютер ашиглах бүрэн боломжийг олгодог. Үүнд:<br>Интернэт хөтөч програмууд, цахим шуудангийн аппликейшнүүд болон хэрэглээний оффисын програм хангамж зэрэг түгээмэл хэрэглэгддэг програмуудыг дэмжиж ажилладаг.<br>- Олон брайль дэлгэцүүдийг дэмжиж ажиллах ба брайль бичвэрийн гарыг ашиглан бичвэр бичих бүрэн боломжтой.<br>- Windows үйлдлийн системийн хувилбарууд болох 32 бит ба 64 битүүдийг дэмждэг.<br>- Мэдрэгчтэй дэлгэцтэй төхөөрөмж дээр ажиллаж байх тохиолдолд бүхий л командыг зарладаг.<br>- Google translate -ийг дэмждэг. | 4 | 4,224.0 | 16,896.0 |
| 6 | Хараагүй хүний таяг | Хараагүй хүний орон зайн баримжааны хэрэгсэл болох сунадаг болон эвхдэг таяг. | 5 | 270.0 | 1,350.0 |
| | | **ДҮН:** | **33** | | **88,646.0** |
| **Сонсголын бэрхшээлтэй хүүхдийг дэмжих тоног төхөөрөмж** | | | | | |
| 1 | Дохионы хэлний цагаан толгой, 1-100 хүртэлх тооны зурагт хуудас | Хүүхдийг хурууны үсэгтэй танилцуулж, тоолж сургахад чиглэгдсэн зурагт хуудас, A2 хэмжээтэй шохойтой цаасан дээр хэвлэсэн өнгөт ханын зурагт, хуудас үзүүлэн. Хурууны үсгийн өндөр нь стандарт шаардлагыг хангасан байх. | 6 | 80.0 | 480.0 |
| 2 | Дохионы хэлний зурган карт 1000 үгтэй | Дохионы хэл заах, үгийн нөөцийг нэмэгдүүлэх, зөв уншиж, бичүүлж сургах зурган карт, Хөзрөн карттай адилхан A7 хэмжээтэй. Картны урд болон ард талд нь зурагтай. Дохионы хэлний зурагт толь бичгийн картан хувилбар бөгөөд авч явахад авсаархан, 10 багц хайрцагуудаас бүрдэх ба хайрцаг тус бүр 100 карттай. | 6 | 500.0 | 3,000.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 3 | Сонсголын алдагдалтай хүмүүст зориулсан таблет | Сонсголын бэрхшээлтэй хүмүүст зориулсан суурин дижитал аудиофон, Дохионы хэлийг текст болон эсрэгээр орчуулах шаардлагатай хүмүүсийн шаардлагыг хангасан, орчин үеийн, сонсголын бэрхшээлтэй хүмүүс сонсголтой хүмүүстэй чөлөөтэй харилцах боломжтой байх. Батарейгаар ажиллахыг дэмждэг байх, мөн тогонд залгаж цэнэглэж болдог байх. Display 10.5", LCD screen OS, 11 GPU, octa core (2x2.0Ghz+6x2.0Ghz) Memory: 4GB (RAM) +128 GB Camera: Front 5MP, Main 8MP Battery: 7040mAh WiFi, Network 802.11 a/b/g/n/ac 2.4 +5Ghz, Bluetooth v5.0 Сонсголын алдагдалтай хүмүүст зориулсан бүх төрлийн апп суулган ашиглах боломжтой. | 6 | 6,500.0 | 39,000.0 |
| **Хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхдийг дэмжих төхөөрөмж** | | | **18** | | **42,480.0** |
| 1 | Харандаа, үзэг бэхлэгч | Харандаа, үзгийг гараас салгахгүйгээр бэхлэх хэрэглэгдэхүүн, Бичих, зурах үед харандаа, үзгийг гарын хуруунд бэхэлж харандааг унагахгүй зурах, бичих боломж олгох зориулалттай сургалтанд ашиглах, өнгө үзэмжтэй эрүүл ахуйн шаардлага хангасан материалтай байх | 60 | 62.0 | 3,720.0 |
| 2 | Хурууны багс | Хүүхэд зурах, будах үед ашиглах хэрэглэгдэхүүн, Багсыг хуруундаа салгахгүйгээр өмсөх боломжтой, сургалтанд ашиглах, өнгө үзэмжтэй эрүүл ахуйн шаардлага хангасан материалтай байх | 30 | 63.6 | 1,908.0 |
| 3 | Суудлын зөөлөвч резин | Удаан суух дургүй хүүхдэд тайвшруулах зорилгоор ашигладаг суудлын зөөлөн резин. Анхаарал төвлөрөл сул сурагчдад ашиглана. Тэнцвэр, анхаарал төвлөрөлтийг сайжруулахын тулд дээр нь суулгах болон зогсох зэргээр хэрэглэнэ. Анхаарал төвлөрүүлэх болон булчингийн хөгжилд тустай. Бат бөх материалтай. Хүүхдийн суудлын хэмжээ 13" диаметр. | 10 | 450.0 | 4,500.0 |
| 4 | Алхагч /Walker/ | Бие даан явж чадахгүй байгаа мөн доод мөчний булчинг хөгжүүлэхэд дэмжлэг болно. 1.Хүүхдийг зогсооход өндөр намыг тохируулдаг байх 2.Бэхэлгээ сайн байх 3.Зөөвөрлөхөд авсаархан буюу дугуйтай байх 4. Дугуй түгжээтэй байх | 18 | 150.0 | 2,700.0 |
| **ДҮН:** | | | **100** | | **12,828.0** |
| **НИЙТ ДҮН:** | | | | | **299,974.0** |

Хянасан:

Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга — О.Хуягцогт

Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга — С.Нансалмаа

Боловсруулсан:

Тэгш хамран сургах боловсролын хэлтсийн ахлах мэргэжилтэн — А.Саруул

Хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн — Б.Түмэнбаяр